

**ВЕНЕСУЭЛ: ЖЕРАЛДИН ЧАКОН**

**ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ**



## **ЗАЛУУЧУУДЫГ ДЭМЖСЭНЭЭРЭЭ МӨРДӨН ШАЛГАГДАВ**

Жералдин Чакон үргэлж бусдыг хамгаалахыг хүсдэг байсан. 9 настайдаа тэрээр хуульч болохыг мөрөөддөг байв. 14 настайдаа орон нутгийнхаа өсвөр үеийнхний эрхийн төлөө тэмцэж байсан. Их сургуульд ороод Эмнести Интернэшнлийн идэвхтнүүдийн сүлжээ бий болгож, өөрчлөлтөнд уриалсан. Ээжийнх нь хэлснээр “тэр ямар нэгэн шударга бус зүйл харвал заавал тэмцдэг” байв.

Энэ хүсэл тэмүүлэл нь түүнийг төрөлх хот Каракасын хамгийн ядуу дүүрэгт амьдардаг залуучуудын төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагад ажиллахад хүргэжээ. Гэвч 2018 оны 2-р сард энэ эрч хүчтэй залуу ажилтныг гэрт нь байхад цагдаа нар баривчилсан байна.

Эрх баригчид түүнийг засгийн газрын эсрэг жагсаал зохион байгуулсан гэх

“эсэргүүцэл”-ийн бүлэглэлтэй холбоотой хэмээн буруутгажээ. Үнэндээ энэ мөрдлөг хавчилга нь Венесуэлийн одоогийн хямралын үеэр хүний эрх зөрчиж байгааг эсэргүүцсэн, эрх баригчдыг шүүмжилсэн тэдгээр хүмүүсийн эсрэг засгийн газраас өргөн хүрээнд хэрэгжүүлж байгаа эрс хатуу арга хэмжээний нэг юм.

Жералдин 4 сарын хугацаанд хүнд нөхцөлд хоригдсоны эцэст 2018 оны 6-р сард батлан даалтаар суллагдсан. Тэрээр эх орноосоо гарах боломжгүй бөгөөд түүнийг мөрдөн шалгах хэрэг нээлттэй үлдсэн тул Жералдиныг хэзээ ч хамаагүй шалтгаангүйгээр дахин баривчилах магадлалтай байна. Венесуэл улсад маш олон идэвхтнүүд улсынхаа сайн сайхны төлөө дуугарснаараа өдөр болгон айлган сүрдүүлэлттэй тулгарсаар байна.



**Венесуэлийн Ерөнхий прокурорт  
хандан захидал бичнэ үү.**

Twitter: @ TarekWilliamSaab

Email: ministeriopublico@mp.gob.ve

Salutation: Señor Fiscal General/ Mr Attorney General



**Жералдинд эв санааны нэгдлээ  
илэрхийлээрэй.**

c/o Amnesty International  
Calle Manuel A. Fuentes 894,  
San Isidro 15046, Lima, Perú